



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/56

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 2019 оны Төсвийн тухай хуулийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд шинээр баригдах барилга байгууламжийн инженер-геологийн судалгааны ажилд зориулан 15 000 000 /Арван таван сая/ төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 15 000 000 төгрөгийг захиалагчийн албаны зардлаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Багдал, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Гантөмөр нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ